

**“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2017 оны 6 сарын 27 өдөр

Улаанбаатар хот

“Хөх ган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 9 цагт эхлэж, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж 9 цаг 30 минутад бүртгэлийн дуусгав.

“Хөх ган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 84,941,923 ширхэг хувьцаатай 9 хувьцаа эзэмшигчид оролцож, хурал 83.84%-ийн ирцтэй байв.

Нийт 9 хувьцаа эзэмшигчдээс 8 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хуралд оролцож, нэг хувьцаа эзэмшигч итгэмжлэл дагуу хуралд хүрэлцэн ирсэн байв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Нийт хувьцаа эзэмшигчдийн 83.84 % буюу 84,941,923 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс саналын хуудас 100% хүчинтэй байсан.

Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар дараах шийдвэр гарав:

Хувьцаа эзэмшигчдээс кумулятив аргаар өгөх нийт хүчинтэй саналын эрх 764,477,307 байлаа. Үүнээс ердийн гишүүнд өгөх саналын тоо 509,651,538, хараат бус гишүүнд өгөх саналын тоо 254,825,769 байв.

ТУЗ-ын ердийн гишүүнээр:

- Б.Мөнхтөр 15.67%-ийн санал
- Ц.Батбаяр: 15.67%-ийн санал
- Ц.Батболд: 15.67%-ийн санал
- Б.Лхагвадорж: 15.64% -ийн санал
- Д.Даянбилгүүн: 15.64%- ийн санал
- Д.Дагвадорж: 15.67%-ийн саналаар,

Хараат бус гишүүнээр:

- Д.Энхбат: 31.37%- ийн санал
- Д.Чинбат: 31.37%-ийн санал
- 1. Х.Батхишиг: 37.27 % -ийн саналаар тус тус сонгогдов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 9:45 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: .....

Хурлын дарга: .....

